



МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМ

2020 оны 09 сарын 15-ны өдөр
хот

Дугаар 12

Улаанбаатар

МОНГОЛ УЛСЫН УИХ-ЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

*ХЭҮК-ын гишүүд болон Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх гишүүнийг
яаралтай томиллох тухай*

Монгол Улсад хүний эрх, эрх чөлөө алхам тутамд зөрчигдөж байгаа энэ үед Хүний эрхийн үндэсний комиссын гишүүдийг нэн яаралтай томилж тус байгууллагын хэвийн, хууль ёсны дагуу ажиллах боломжийг бүрдүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай болохыг сануулах зорилгоор хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 50 орчим ТББ-ыг эгнээндээ нэгтгэсэн Хүний эрхийн форумын гишүүд бид энэхүү захидлыг бичиж байна.

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг НҮБ-ын хүний эрхийн механизмаас өгсөн зөвлөмжид нийцүүлэн шинэчлэн баталж, Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнийг сонгон шалгаруулах үйл явцад гарсан ахиц дэвшлийг ХЭФ тун талархалтай хүлээн авсан билээ. Ялангуяа 2020 оны 6 сарын 10-11-ний өдрүүдэд явагдсан томилгооны сонголт нь хүний эрхийн мэдлэг, туршлагатай байх шалгуур үзүүлэлтийг хангасан нэр дэвшигчийг сонгон шалгаруулахад үр дүнтэй, оновчтой алхам болсны зэрэгцээ аливаа дээд албан тушаалд тохирох албан тушаалтныг сонгон шалгаруулахад цаашид жишиг болохуйц болсныг бид ихэд сайшааж байна. Гэвч сонгон шалгаруулалтын дүнг танилцуулах, томилох явц удааширалтай байгаад сэтгэл дундуур байна.

Хүний эрхийн үндэсний комиссын сонгон шалгаруулалтад хангалттай тооны ур чадвартай хүмүүс нэр дэвшсэн тул Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн болон Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх гишүүний томилгоог УИХ-аар яаралтай хэлэлцэж, батламжлах үйл явцыг түргэсгэхэд Таныг манлайлан ажиллана хэмээн найдаж байна.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, НҮБ, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө авсан үүрэг амлалтаа биелүүлэх, цаашлаад Тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцсэн алхам билээ.

Хүндэтгэсэн,

ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМЫН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУД

Монголын хүний эрхийн форумын энэ сарын жижүүр ЛГБТ Төв ТББ

Утас: 89387677

Имэйл хаяг: info@lgbtcentre.mn